Д.ПҮРЭВСҮРЭН

“Уянгалах мэт нам гүм Монголын тал нутаг. Нам гүмийг цочоож цуурайтах мэт болж, хийморь сэргээм омголон, зах нь үл харагдах адуун сүрэг идэр цогтой хуйлран давхилдана. Морьд бие биеэсээ нэг холдон эргэж нийлэн амьсгал давчдам хурд хэмнэлээр нижигнэн бүжих мэт болно. Тэнгис мэт эрчлэн долгиолж, өнгөөр солонгорон давалгаалах дүрслэл нь нэг бүрчлэн тод сониноор ялгарна. Тэд тэнгэр газрыг холбох тэр нэгэн цэг болох ертөнцийн хязгаар руу хуйлран давхилдана” гэж Германы “Avinth film Berlin” продашкн нэгэн монгол зураачийн тухай хийсэн баримтат кинонд гарч байна. Үнэхээр түүний “Туурайн төвөргөөн” зурагт нэг ч хөдөлгөөн давтагдаагүй мянга мянган морьдыг маш жижиг хэмжээтэй зурсан нь холоос далайн давалгаа эсвэл хээ угалз мэт солонгорч харагдана. Энэ бол зураач Э.Отгонбаяр. Тэрээр Германд “Зураг” нэртэй галерейг байгуулж, уран бүтээлээр үргэлж буцалж явдаг нэгэн. Өөрөөр хэлбэл, барууны ертөнцийн тэр их хөл үймээнтэй, урлагийн өндөр мэдрэмжтэй ард түмэн дунд өөрийн гэсэн өнгө төрх, орон зайгаа тод гортиглосон зураач. Учир нь түүний гаргасан үзэсгэлэн болгон олны анхааралд байдгийг онлайн ертөнцийн нээлттэй хаалгаар орж үзэж болно. Монголын төр, нийгмийн томчууд ч Германаар очихдоо заавал Э.Отгонбаярын галерейгаар зочилдог юм билээ.



“ХҮН” зураг 660 х 217 см, акрил зотон 2010-2012 ОТГО арт Берлин (ХҮН зурагт 11196 орчим хүн амьтны дүрслэл багтсан болно.

# ДЭЛХИЙД ДАНСТАЙ МИНИАТУР ЗУРААЧ



ХБНГУ-ын Ерөнхийлөгч Ё.Гаук (Joachim Gauck) болон ОТГО арт, Бельвю ордон (Schloss Bellevue) 2012.3.29 Берлин

Түүний уран бүтээлийн гол чиглэл нь миниатур урлаг. Миниатур нь жижиг зураг гэсэн утгатай үг бөгөөд маш нарийн ажиллагаатай жижиг хэмжээний уран бүтээлийн төрөл аж. Харин Монголын уламжлалт урлаг болох монгол зураг миниатур урлагтай нягт холбоотой бөгөөд нэг тод жишээ нь бурханы зураг аж. Тиймээс Э.Отгонбаярын урын сангийн багагүй хэсгийг бурханы хөрөг бүтээлүүд эзэлдэг юм билээ. Мөн эх орныхоо түүх соёлыг сурталчлах үүднээс “Монголын нууц товчоо”-г монгол зургийн аргаар бүтээжээ. Ингээд зураач Э.ОТГОНБАЯРТАЙ онлайнаар ярилцсанаа хүргэе.

## БИ ӨӨРЧЛӨГДӨХ УЧИРТАЙ, ЯАЖ ӨӨРЧЛӨГДӨХ НЬ Ч ТОДОРХОЙ БАЙГАА

**-Шинэ үзэсгэлэнгээ нээгээд удаагүй байна. Эндээс яриагаа эхэлье. Таны зохион байгуулсан үзэсгэлэн болгон давтагдашгүй онцлогтой санагддаг. Энэ удаагийн үзэсгэлэнгийн гол онцлог юу байв?**

-Энэ удаагийн үзэсгэлэнгийн онцлог нь миниатур буюу нарийн чимхлүүр ажиллагаа бүхий жижиг хэмжээтэй, олон төрлийн сэдэвтэй 260 гаруй миниатур зургууд багтсан. 13 жилийн турш миний хийсэн бүтээл. Тухайлбал, 17,5 х 24 хэмжээ бүхий “Kama sutra Miniature” зурганд загас наадуулж буй мянган орчим хүнийг дүрсэлсэн бөгөөд тэдгээр хүний зөвхөн толгойн хэмжээ нь шар будаанаас багахан боловч томруулдаг шилээр харвал царай зүс, сэтгэлийн хөдөлгөөн нь танигдана.

**-Уран зургийн тухай гүнзгий ойлголтгүй хүн ч гэсэн таны зургийг хараад анхны сэтгэгдэл гайхшрал байх болов уу. Тэгээд тэдний асуулт “энэ нарийн чимхлүүр бүтээлийг гараар хийсэн гэж үү” гэж асуух болов уу?**

-Би маш том бас маш жижиг хэмжээтэй талбайд нарийн ажиллагаатай зураг зурдаг. Анх харсан хүнд хийсвэр сэтгэлгээтэй, өнгөний тоглолттой орчин үеийн уран бүтээл үзэгдэх байх. Ойртож харах тусам тэр бүтээл амилсаар, хүн болгон ойлгож болохоор тодорхой дүрслэл рүүгээ орж ирдэг. Үзэсгэлэнг маань үзээд сайхан магтаал өгөх үзэгчид байлгүй яахав. Тэр бүхнийг дурдвал өөрийгөө магтсан болох болов уу.

**- Уран зургийн төгс нь Жоканда гэвэл монгол зургийн төгс нь Цагаан дарь эх гэж та хэлсэн байсан. Миниатур урлаг хийгээд монгол зургийг та хэдийнээс судалж, бүтээлээ туурвиж эхэлсэн бэ?**

-Дүрслэх урлагийн дунд сургуулийн монгол зургийн ангийг 1998 онд төгсөөд энэ чиглэлээр уран бүтээлээ үргэлжлүүлэн хийж, үндэс түүхийг нь боломжийн хэрээр судлах болсон. 1998-2005 онд зурах техник талаас, 2005-2010 онд онд түүхэн сурвалж талаар нь голдуу судалсан. Герман хэл дээр бичсэн түүхийн болон урлагийн номуудад монгол урлагтай холбоотой зүйлсийг яаж бичсэн талаар сонирхон уншихад монгол зурагтай холбоотой багагүй материал байдаг юм билээ.

**-Энэ талын судалгаа ч, төлөөлөл болох уран бүтээлч цөөн байдаг бол монгол зураг урлагийн цоо шинэ төрөл байж болох уу. Хөгжлийг нь та яаж харж байна вэ?**

-Энэ бол урлагийн цоо шинэ төрөл биш. Харамсалтай нь, сүүлийн үеийн зарим нэгэн монгол зургийг үзэхээр Япон, Хятад, Солонгос зургийн стильтэй болсон харагдах юм. Азийн олон зургийн стилийг гадны хүн битгий хэл ази хүмүүс ялгаж салгахад хялбар биш болохоор тэгдэг байх.

Монгол зургийн уламжлалаас эхтэй орчин үеийн хийсвэр, чөлөөт сэтгэлгээтэй уран бүтээл монгол зургийн хөгжлийг авч явна. Орчин үед урлагийг уран бүтээл ба гар урлал гэж ангилан мэтгэлцэх нь элбэг байгаа. Тэр гар урлалд нь орчин үеийн монгол зураг бодит дүрслэлтэйгээ буюу морь, тэмээ, гэр, байгаль, баатар, анчинтайгаа XXI зуунд орж ирсэн. Хэрэв одоо үед ийм дүрслэлтэй бүтээл гарч ирвэл урлаг судалаачид түүнийг XIX-XX зуундаа үлдсэн урлаг гэнэ. Өөрөөр хэлбэл, орчин үеийн урлаг биш гар урлал, чимэглэл, худалдааны ажил буюу бэлэг дурсгалын урлаг гэж тодорхойлоод байдаг. Монголд одоо байгаль, баатар, анчин зурж байгаа маш олон мэргэжлийн уран бүтээлч байна. Гэтэл баруунд орчин үеийн мэргэжлийн уран бүтээлч байгаль зурвал тэд өөрсдөөсөө ичнэ.

**-Таны уран бүтээлийн нэг чиглэл бурханы зураг. Бурханы урлал миниатур урлагтай яаж холбогдож байна вэ. Тэр болгон зураач бурхан зурчихдаггүй гэдэг. Бурхан зурахын тулд та хэр хугацаанд судалгаа хийсэн бэ?**

-Бурханы зураг нарийн чимхлүүр ажиллагаатай байдаг болохоор миниатур арттай холбогдож байдаг. Би бурханы зураг зурахаа болиод удаж байна. 1999-2005 онд би 600 гаруй бурхан зурсан байна лээ. Бурхан бүтээгээд өгөөч гэсэн хүсэлтүүд их ирдэг. Харин би бурханы зургийг шашны талаас нь биш урлагийн бүтээл гэдэг утгаар нь бодож хандаж ирсэн болохоор алдаатай зүйл хийчих вий, хүний сүсэг бишрэлийг сэвтүүлчих вий гэсэндээ ихэнхдээ татгалздаг. Тэгэхээр энэ 600 бүтээл бурханы зураг биш уран зураг юм. Аравнайлуулаагүй гэсэн үг.

**-Яагаад бурхан зурахаа больсныг сонирхмоор байна?**

-Бурхан зурсан нь өөрийгөө сорьсон ажил болсон юм. Би бурханы зургаас маш их зүйл суралцсан. Монгол зурагт байдаг хамгийн чухал элементүүдийг бурханы зураг зурснаар мэдэж, суралцаж, судалж болно. Миний хувьд бурханы зураг бол урлагийн бүтээл. Би дандаа тэгж хардаг байсан. Харин монголчууд түүнийг шашинлаг болгож туйлшруулаад байх юм. Алдаатай зурвал алдас, зөв зурвал буян болно гэдэг. Бурханы зураг төгс, сонгодог утгаа аль хэдийнэ олон зуун жилийн өмнө олсон. Эртний мастерууд хүн яаж төгс төгөлдөр зурж болдгийг харуулж өгсөн байдаг. Үүнийг бид Занабазарын музейд ороод л шууд мэдэрч болно. Харин би шинэ, өөрийн гэсэн өнгө аястай “Отгоо”-гийнх гэсэн бүтээл хиймээр байна.

**-Та өөрийн гэсэн өнгө аясаа олсон юм биш үү?**

-Болоогүй ээ. Би их өөрчлөгдөх учиртай. Яаж өөрчлөгдөх нь бас тодорхой байгаа. Уламжлалыг ойлгохгүйгээр орчин үеийг ойлгож чадахгүй шүү дээ. Бурханы зургийг өчигдрийн урлаг гэж үздэг. Одоо хийж байгаагаа өнөөдрийн урлаг гэж боддог. Хэрэв би одоо ирээдүйн урлаг хийж чадвал хүссэн юм бүтлээ гэсэн үг. Ирээдүйн урлаг гэдэг нь миний бүтээлийг 2050 онд харсан хүмүүст орчин үеийн санагдахаар байна гэсэн үг. Ямар нэгэн цаг хугацаа төрөл жанарт баригдахгүй гэсэн үг. Яг ийм бүтээл туурвихсан гэж эрэл хайгуул хийж, мөрөөдөж явдаг хүн дээ.

## ОНГОД ГЭЖ БАЙДАГ БОЛ НЭГ БҮТЭЭЛЭЭС НӨГӨӨ БҮТЭЭЛ ТӨРӨХ ТЭР АГШИН

**- Та зарим өдөр зөвхөн ус уугаад өдөржин уран бүтээлээ хийгээд, түүндээ уусч суудаг гэсэн. Нэг ёсны бясалгал юм шиг санагдсан. Ер нь уран бүтээл хийж суухад төрдөг мэдрэмжээс тань хуваалцмаар байна?**

-Сайхан дуу сонсоод зураг зурах дуртай. Уран бүтээлийг олон цаг хийж байх үед нүд чилэх гээд байдгийг эс тооцвол ер нь ядардаггүй. Их тайван байдалд ороод ирэхийн цагт ертөнцөөс тасарсан ч юм шиг мэдрэмж төрнө. Яг зорилготой шамдуухан ажиллаж байх үедээ хоол бага идэх юм уу, заримдаа юу ч иддэггүй. Тайван байдалд байгаа хүн өөрийгөө их чагнаж мэдэрдэг юм. Хоол идчихээр ходоод ажиллаад толгой ажиллахгүй байгаа мэт санагдаж, хийж байгаа уран бүтээл минь удаашраад, анхаарал сарниад, заримдаа нойр хүрээд ирдэг юм. Би сүүлд зурж дуусгасан “Hun” 660x217 см хэмжээтэй бүтээл дээрээ хоёр жилийн турш өдөрт 14 цаг хоол идэхгүйгээр ажиллаад орой гэртээ ирж, 200 гр улаан вино уугаад нам унтаж, маргааш өглөө нь цайгаа уудаг байсан. Уран бүтээлийнхээ гүнд орж ажиллах үед хэн нэгэн дэргэд байх нь надад ерөөсөө саад болдоггүй.

**-Уран бүтээлээсээ авдаг хамгийн том таашаал юу байдаг вэ. Өөрөөр хэлбэл, та хэдийд нэг сайхан урт санаа алдаад юм уу, өөрийн эрхгүй инээмсэглэл төрдөг вэ?**

-Үзэсгэлэнгээ гаргаад хүмүүс яаж хүлээж авч байгааг харах хамгийн сайхан байдаг.

**-Таны уран бүтээлийн өнгө аяс болон бусад зүйл их үндсэрхэг хүн гэсэн үнэр ханхалдаг?**

-Би үндсэрхэг хүн биш. Миний амьдарч байгаа Берлин хотын таван хүн бүрийн нэг нь гадаад хүн. Янз бүрийн үндэстэн холилдсон дэлхийн том улсад Монголын урлагийн нэгэн төлөөлөгч болж яваа хүний хувьд хийх зүйл маш их байна. Би хаана байна, монгол гэсэн үг дагаж явдаг болохоор хариуцлага өндөр. Монголоос ирсэн гэдгээ үргэлж бахархалтайгаар хэлж явахсан гэж хичээдэг дээ.

**-Өнөөдрийн өнцгөөс таныг харахад эх орныхоо нэрийг гаргаж яваа, олон улсад танигдсан, чадварлаг уран бүтээлч. Энд хүрэхэд та хэр их хүч хөдөлмөр зарцуулсан бэ?**

-Уйгагүй хүн уул нүхэлнэ гэдэг шиг л юм болсон байх. Анх онгоцныхоо тийзийг өр тавьж аваад халаасандаа 120 доллартай Берлинд ирж байлаа. Германы урлагийн хамгийн том их сургуульд сурч байхдаа аар саар ажил хийж одоогийн энэ байдалд хүртлээ багагүй хөлсөө урсгасан. Өөрийн хувийн уран зургийн галерейгаа Берлинд байгуулаад хоёр жил болох хугацаандаа зөвхөн Монголын урлагийг гэж явсангүй. Герман, Перу, Швейцарь, Турк уран бүтээлчдийг дэмжин ажиллаж, үзэсгэлэн гаргаж байна. Герман уран бүтээлчийн үзэсгэлэнг хаа холын Монголоос ирсэн хүн эх оронд нь мэргэжлийн төвшинд гаргаж байна гэсэн гарчигтай нийтлэл эндхийн сонинд гарсан байхыг уншиж ихэд урамшиж билээ.

**-Та гадаадад амьдарч байгаагаа нүүдэлч удмынхаа адил нүүж яваагаар тайлбарласан тань их таалагдсан. Тэр нүүдэл хэзээ эх орондоо бууриа засах вэ. Чадвартай, бас үндэстнээ гэсэн сэтгэлтэй монголчуудаа харамлах сэтгэл төрсөндөө энэ асуултыг сэтгүүлчид танаас их асуудаг байх?**

-Хээрийн галуу нисэн үл хүрэх газраас хүний хүү эрдэм өвөртлөж ирнэ гэдэг шүү дээ. Буцах болоогүй, энд хэсэг амьдрах хүсэл байна. Санхүүгийн асуудлаас болоод бодож санаснаа тэр бүр хийж чадахгүй үе байдаг ч бидэнд маш их боломж чадвар байгаа гэдэгт эргэлздэггүй. Нас яваад ирэхийн цагт урлаг судлаач, урлагийн түүхч багш болохсон гэж боддог.

**-Уран бүтээл хийх онгод гэж яриад байдаг. Таны бүтээл хийх тэр өгөгдөл хаанаас ирдэг вэ?**

-Би нэг дор олон бүтээл эхэлчихдэг, эхнийх нь дуусаагүй байхад дахин шинэ санаа орж ирээд, яг тэр агшинг мартахгүй гэсэндээ өөр нэгийг эхлүүлээд орхичихно. Иймд миний хувьд онгод гэж байдаг бол нэг бүтээлээс нөгөө бүтээл төрж байдаг тэр агшинг гэж бодож байна.

**-Зураг болгонд зураачийн дотоод сэтгэл агуулагддаг байх. Тэр дундаас таныг хамгийн сайн илэрхийлэх ч гэдэг юм уу, хамгийн түрүүнд нэрлэх бүтээл гэвэл?**

-Хамгийн сүүлд зурсан бүтээлээ нэрлэх байх. Ер нь сүүлд бүтээснээ өмнөхтэйгөө харьцуулахад өмнөх нь гологдох шиг болдог.

**-Бас хамгийн их цаг хугацаа зарцуулсан эсвэл их түүхтэй бүтээл гэвэл?**

-“Монголын нууц товчоо” гэж монгол зургийн аргаар хийсэн бүтээл. Үүн дээр 1998 оноос хойш ажиллаж байна. 600 хуудастай 3000 орчим зураг орсон энэ номыг хийхийн тулд маш олон сонирхолтой хүнтэй уулзаж явсан даа.



2011 онд Францад болсон нэгэн үзэсгэлэн дээр

## ДОЛООН ЖИЛ НУТГИЙНХАА ЗУНЫГ ҮЗСЭНГҮЙ

**-Таны нэг өдөр яаж өнгөрдөг вэ?**

-Өдөр болгон адилгүй ээ. Өглөө 07.00 цагаас босч 02.00 цагт орондоо ордог. Миний хань оюутан, бид бага насны хоёр хүүхэдтэй болохоор хийх ажил мундахгүй дээ.

**-Таны дуртай өнгө. Аль өнгө таны бүтээлд давамгайлдаг вэ. яагаад?**

-Би тийм өнгөнд дуртай, ийм өнгөнд дургүй гэдэггүй ээ. Бүх өнгө өөрийн гэсэн хүчтэй, өнгөөр хүнийг инээлгэж, уурлуулж, таатай мэдрэмж төрүүлж болдог. Тиймээс өнгөнөөс өнгө үүсгэж, сайхан эсвэл муухай өнгө гаргаж ирэх нь зураач хүний гол ажил юм. Өөрөөр хэлбэл, будагнаас өнгийг төрүүлнэ гэсэн үг.

**-Таны бүтээл ойролцоогоор хэдэн төгрөгөөр үнэлэгддэг вэ?**

-Би сүүлийн жилүүдэд монгол мөнгөөр зураг зураагүй юм байна. Хэрэв төгрөг рүү оруулж үзвэл нэг бүтээлийн үнэ долоогоос найман оронтой тоо болох гээд байна.

**-Уран бүтээлийн урын санг тоогоор хэлбэл?**

-Чөлөөт сэтгэлгээний уран бүтээлийг тооцохгүйгээр бурхад болон “Монголын нууц товчоо”-ны зургууд нийлээд 4000 орчим миниатур зураг болж байна.

**-Монголоос олны танил эрхмүүд таны урланд их зочилдог шиг байна лээ. Тэдэнд зургаа бэлэглэх ч юм уу, тэд худалдаж авсан тохиолдлын талаар?**

-Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржид “Монголын нууц товчоо” номынхоо хамгийн анхны хувилбар болох 620 хуудастай номоо бэлэглэсэн.

**-Одоо та ямар бүтээл дээр ажиллаж байна вэ?**

-Энэ найман сард Улаанбаатар хотод болох үзэсгэлэнгийн шинэ уран бүтээлүүд дээр ажиллаж байна.

**-Хэр хугацааны дараа үзэсгэлэнгээ гаргаж байна вэ. Өмнө нь энд гаргаж байсан биз дээ?**

-Долоон жил үзэсгэлэн гаргаагүй, долоон жил нутгийнхаа зуныг үзээгүй юм байна. Өвлийн улиралд л хэд хэдэн удаа очсон.